



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 4/23

Мандалговь

Г

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “Малчны хөгжлийг дэмжих төвийн зураг төсөв, ТЭЗҮ боловсруулах “зөвлөхийн үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Адъяасүрэн (Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг гүйцэтгэгч)

Гишүүд:

Ж.Уянга (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Э.Дүүрэнжаргал (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

Ю.Отгондэлгэр (Иргэний төлөөлөл)

Нарийн бичиг:

Б.Сайхантуяа (Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Адъяасүрэн)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Сайхантуяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МОНХБАТ

48 12100519